



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2022.08.15 № ЦАТ-11/01/011

танай 2022.08.09 -ны № 02/02 -т

Г Хаяг, байршлын өөрчлөлтийг 7
бүртгэсэн тухай

Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу танай хаяг байршлыг өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг хянаж нь “Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4-р хороо, Наадамчид гудамж, 617-р байр, 3 тоот” хаягт бүртгэлтэй байсныг “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол, Алтай гудамж-281, “Хоймор оффис”, 6 давхар, 603 тоот” гэж шинэчлэн бүртгэсэн болно.

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ", Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 6.9 дэх хэсэгт "Хаягийн өөрчлөлтийг бүртгэсэн бол тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ" гэж заасны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээнд хаягийн өөрчлөлтийг даруй хийлгэж Хорооны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад дээрх хаягийн өөрчлөлтийн тэмдэглэгээг хийлгэнэ ҮҮ.

Компанийн хаяг, байршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор харилцагч, үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх талаар анхаарч ажиллахыг хүсье.

